



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жамжин Д. Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn.

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.09.18 № ХЭГ/3166
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас хууль тогтоомжийн биелэлтийн мэдээлэл ирүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгатай холбогдуулан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд 2024-2026 онд улсын төсвөөс татаас хэлбэрээр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хяналт-шинжилгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 25 хуудастай.

Хүндэтгэсэн,



Монгол Улсын Засгийн газар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Баттөмөр Энхбаяр

2026.09.18 11:23

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ХҮРЭЭНД 2024-2026 ОНД УЛСЫН ТӨСВӨӨС ТАТААС
ХЭЛБЭРЭЭР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**НЭГ. "ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ
ХҮРЭЭНД ОЛГОСОН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ**

1.1. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хэрэгжилт:

"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэхээр шийдвэрлэж, уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нийт 5 зорилт, 114 арга хэмжээтэйгээр баталсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 2026 оны хагас жилийн байдлаар 80.3 хувьтай байна.

Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолоор хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хөнгөлөлт 13.0 нэгж хүртэл хувь байх шийдвэрийг гаргасан бөгөөд Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч нарын хамтран баталсан зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд тусгагдсан зээлийн зориулалт, ерөнхий нөхцөл, шаардлага зэргийг үндэслэн арилжааны 10 банкаар дамжуулан 2023-2024 онд нийт 1.3 их наяд (1,261.5 тэрбум) төгрөгийн зээлийг 982 аж ахуйн нэгж, 1,540 иргэнд 3-5 жилийн хугацаатай олгосон. Нийт олгосон зээлийн 48 хувь буюу 611.0 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгийн, 52 хувь буюу 650.4 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын чиглэлийн зээл байна.

1.2. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл олголт, улсын төсвөөс хариуцан төлсөн хүүгийн дэмжлэгийн гүйцэтгэл:

Энэхүү зээлийг хүнсний үйлдвэрлэлийн сүлжээний үе шат бүрд олгохыг зорьсон бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэлд 8 хувь буюу 102.2 тэрбум төгрөгийн зээлийг 154 зээлдэгчид, газар тариалангийн үйлдвэрлэлд 29.6 хувь буюу 373.3 тэрбум төгрөгийн зээлийг 1,955 зээлдэгчид, хүнсний боловсруулах болон сав, баглаа боодлын үйлдвэрлэлд 62.3 хувь буюу 785.7 тэрбум төгрөгийн зээлийг 413 аж ахуйн нэгжид тус тус олгосон байна.

Хөрөнгө оруулалтын зээл олголт:

Зээлийн зориулалт, ангилал	2023 он		2024 он		НИЙТ	
	Олгосон дүн	Зээлийн тоо	Олгосон дүн	Зээлийн тоо	Олгосон дүн	Зээлийн тоо
Газар тариалангийн салбар						
Анхан шатны үр үржүүлгийн төв, үтрэм байгуулах	6.12	16	5.34	11	11.46	27
Зоорийн аж ахуй байгуулах	50.80	49	34.12	32	84.92	81

Улаанбуудайн тариалангийн инженерийн хийцтэй услалтын систем байгуулах	1.52	3	-	-	1.52	3
Хүлэмжийн аж ахуй байгуулах	11.83	22	2.22	4	14.05	26
Хүнс, газар тариалан (үр тариа)-ийн техник, тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	30.30	62	-	-	30.30	62
Бүх төрлийн будаа, чихрийн манжин тариалах услалтын систем	-	-	-	-	-	-
Газар тариалангийн хөрөнгө оруулалтын зээлийн дүн	100.60	152	41.68	47	142.28	199
Мал аж ахуйн салбар						
Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	0.045	1	9.52	10	9.57	11
Тахианы аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	19.33	7	24.97	6	44.30	13
Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	-	-	9.00	12	9.00	12
Мал, амьтны гоц халдварт өвчний эсрэг вакцин, бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх	-	-	3.49	1	3.49	1
Мал аж ахуйн хөрөнгө оруулалтын зээлийн дүн	19.38	8	46.98	29	66.36	37
Хүнсний үйлдвэрийн салбар						
Орон нутагт сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хэрэглээнд зориулан хүнсний үйлдвэр байгуулах	26.55	30	13.88	15	40.43	45
Хүнсний давс боловсруулах үйлдвэр байгуулах	0.93	4	0.10	1	1.03	5
Хүнс, газар тариалан (үр тариа)-ийн техник, тоног төхөөрөмж, тусгай тээврийн хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	145.63	127	85.77	115	231.40	242
Хүнсний ногоо, модны үрсэлгээ, тарьц суулгацын бортогоны үйлдвэр байгуулах	0.2	1	-	0	0.20	1
Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	19.9	9	19.44	5	39.34	14
Хүүхдийн хоол, хүнсний хэрэглээнд зориулан ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	10.4	8	5.20	2	15.60	10
Хүүхдэд зориулсан, импортыг орлох бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах	93.12	26	15.64	12	108.76	38
Хүнсний үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зээлийн дүн	296.73	205	140.03	150	436.76	355
Хүнсний сав, баглаа, хүнсний ногооны хадгалалт, тээвэрлэлтийн зориулалтын хуванцар тэвшний үйлдвэр байгуулах	5	1	-	-	5	1
Нийт хөрөнгө оруулалтын зээлийн дүн	421.71	366	228.70	226	650.40	592

Эргэлтийн хөрөнгийн зээл олголт:

Зээлийн зориулалт, ангилал	2023 он		2024 он		НИЙТ	
	Олгосон дүн	Зээлдэгчийн тоо	Олгосон дүн	Зээлдэгчийн тоо	Олгосон дүн	Зээлдэгчийн тоо
Газар тариалангийн салбар						
Газар тариалангийн үйлдвэрлэл	90.91	660	92.32	480	183.23	1150
Хүнсний ногооны үйлдвэрлэл	25.28	567	22.84	416	48.12	970
Газар тариалангийн эргэлтийн хөрөнгийн зээлийн дүн	116.2	1227	115.16	896	231.35	2120
Мал аж ахуйн салбар						
Тэжээлийн үйлдвэрлэл	2.97	5	1.00	1	3.97	6
Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй	6.83	52	-	-	6.83	52
Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй	19.36	35	-	-	19.36	35
Гахайны аж ахуй	0.38	8	-	-	0.38	8
Тахианы аж ахуй	4.28	11	-	-	4.28	11
Зөгийн балын экспорт	0.99	21	-	-	0.99	21
Мал аж ахуйн эргэлтийн хөрөнгийн зээлийн дүн	34.81	132	1.00	1	35.81	133
Хүнсний үйлдвэрийн салбар						
Хүнсний боловсруулах үйлдвэр эргэлтийн хөрөнгө	243.42	221	83.88	75	327.30	290
Хүнсний сав, баглаа боодол эргэлтийн хөрөнгөөр дэмжих	16.6	10	0	0	16.60	8
Хүнсний үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийн дүн	260.02	231	83.88	75	343.90	298
Нийт эргэлтийн хөрөнгийн зээлийн дүн	411.03	1,590	200.04	972	611.06	2,551

Улсын төсвөөс зээлийн хүүгийн хөнгөлөлтөд олгосон төсвийн гүйцэтгэл:

Татаас	2024 он			2025 он			2026 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл	121.0	120.9	100%	88.2	51.8	59%	58.9	53.9	91%

2026 оны хагас жилийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 377.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд зээлийн хүүгийн хөнгөлөлтөд улсын төсвөөс 2026 оны хагас жилийн байдлаар нийт 226.6 тэрбум төгрөгийг олгоод байна. (2023-2026.06 сар)

1.3.Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл олгосон салбаруудын арга хэмжээний зорилтын хэрэгжилт:

1.3.1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн хүрээнд:

Улаанбуудайн усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, таримлын шинэ сортыг нутагшуулах, турших, тэдгээрийн сортын элит баталгаат үр үржүүлэхийг дэмжих, бордоо болон техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээг газар тариалангийн үйлдвэрлэлийн технологит хугацаанд авч хэрэгжүүлсний үр дүнд 2025 онд тариалангийн эргэлтийн талбайн хэмжээ 8.1 хувь буюу 83.1 мянган га, зоорийн багтаамж 13 хувь буюу 33 мянган тонн, хүлэмж 24.0 хувь буюу 34.5 га-аар тус тус нэмэгдсэн байна.

2025 оны ургацыг 2022 онтой харьцуулахад үр тариа 295 мянган тонныг хураан авч 13 хувиар буурсан, хүнсний ногоо 240 мянган тонныг хураан авч 61 хувиар өссөн, төмс 114 мянган тонныг хураан авч 47 хувиар буурсан, тэжээлийн ургамал 198 мянган тонныг хураан авч 16 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тодруулбал, 2025 оны нийт ургацын хэмжээг 2022 оны дүнтэй харьцуулахад 13 хувиар буурсан буюу гантай холбоотойгоор бүх нутгаар ургацын хэмжээ буурсан. Харин 2024 оны нийт ургацын хэмжээг 2022 оны дүнтэй харьцуулахад 28 хувиар өссөн байна.

Мөн 2025 оны байдлаар цагаан будаа, шар буурцаг, эрдэнэшиш, наранцэцэг, судан гэсэн 5 нэр төрлийн ургамлыг шинээр тариалсан байна.

Жимс, жимсгэний талбайн тухайд 2022 онд 7.1 мянган га байсан бол 2025 онд 7.4 мянган га болж 300 га-аар буюу 4 хувиар нэмэгдсэн байна. Мөн бордооны хэрэглээ 2022 онд 4.5 мянган тонн байсан бол 2025 онд 15.7 мянган тонн болж 3.4 дахин өссөн байна.

1.3.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээнд:

Ашиг шимт үхрийн тоо 2024 онд 245.3 мянган толгой байсан бол 2025 онд 269 мянган толгой болсон. Өндөглөгчийн тухайд 2025 оны (2.2 сая тахиа) дүнг 2022 оны (1.5 сая тахиа) дүнтэй харьцуулахад 46.6 хувиар нэмэгдсэн байна.

Тэжээлийн үйлдвэр, цехийн хүчин чадал 2022 онд 331 тонн/өдөр байсан бол 2025 онд 491 тонн/өдөр болж 160 тонн/өдөр буюу 40 хувиар, зөгийн бүлийн тоо 2022 онд 12.8 мянга байсан бол 2025 онд 15.3 мянган бүл болж 20 хувиар тус тус өссөн байна.

Махны үйлдвэрлэл 2022 онд 650.1 мянган тонн байсан бол 2025 онд 700.0 мянган тонн болж 50 мянган тонн буюу 8 хувиар, сүүний үйлдвэрлэл 2022 онд 220.7 мянган тонн байсан бол 2025 онд 295.4 мянган тонн болж 74.7 мянган тонн буюу 34 хувиар, өндөгний үйлдвэрлэл 2022 онд 11.7 мянган тонн байсан бол 2025 онд 12.2 мянган тонн болж 4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

1.3.3. Хүнсний боловсруулах болон сав, баглаа боодлын үйлдвэрлэлд:

Хүнсний үйлдвэр шинээр барих, өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулах, хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний хүрээнд хүнсний шинэ 53 үйлдвэр, үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүний 11, мал төхөөрөх

10, мах боловсруулах 7, гурилан бүтээгдэхүүний 16, ургамлын гаралтай бүтээгдэхүүний 3, шингэн хүнсний бүтээгдэхүүний 3, давсны 1, сав, баглаа боодлын 2 үйлдвэр тус тус байгуулагдсанаас 42 нь ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Хүнсний үйлдвэр 2022 онд 884 байсан бол 2025 оны байдлаар 937 болж 53 үйлдвэрээр нэмэгдсэн. Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл 2022 онд 3183 байсан бол 2025 онд 4209 болж 1026 нэр төрөл буюу 32 хувиар, ажлын байр 2022 онд 7000 хүн байсан бол 2025 онд 10000 хүн болж 3000 буюу 42 хувиар, хүчин чадал 2022 онд 231.7 мянган тонн байсан бол 2025 онд 324.2 мянган тонн болж 92.5 мянган тонн буюу 40 хувиар тус тус нэмэгдсэн байна. Тухайлбал:

Мах, махан бүтээгдэхүүн: Мал төхөөрөх, мах боловсруулах 17, үүнээс ашиглалтад 14 үйлдвэр орсон бөгөөд Улаанбаатарт 4, Хэнтийд 3, Дархан-Уулд 2, Булганд 2, Орхонд 2, Төвд 1 тус тус, мал төхөөрөх үйлдвэрийн хүчин чадал 49 хувиар, мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 4.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүн: Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр 11, үүнээс ашиглалтад 9 үйлдвэр орсон бөгөөд Улаанбаатарт 4, Архангайд 2, Төвд 1, Дорнодод 1, Сүхбаатарт 1 тус тус, хүчин чадлын тухайд 64 хувиар нэмэгдсэн байна.

Гурил, гурилан бүтээгдэхүүн: Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр 16, үүнээс ашиглалтад 13 үйлдвэр орсон бөгөөд Архангайд 1, Увсад 1, Улаанбаатарт 9, Дорноговьд 1, хүчин чадлын тухайд 16 хувиар нэмэгдсэн байна.

Бусад хүнсний бүтээгдэхүүн: Шинээр 9 үйлдвэр, үүнээс ашиглалтад 7 үйлдвэр орсон бөгөөд Улаанбаатарт 6, Хөвсгөлд 1 тус тус, ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрийн хүчин чадал 29 хувиар, давсны үйлдвэр 4 хувиар, шингэн хүнс 14 хувиар тус тус нэмэгдсэн байна.

1.4.Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн үр дүн, хүрсэн түвшний үзүүлэлт:

1.4.1.Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо

Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо 2022 онд 3199 байсан бол 2026 оны 2 дугаар улиралд 5039 болж 57.5 хувиар, хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо 2022 онд 1981 байсан бол 2026 оны 2 дугаар улиралд 2663 болж 34.4 хувиар тус тус өссөн байна.

Салбар	2022 он	2026 оны II улирал	Өөрчлөлт	Өсөлт, %
Хөдөө аж ахуйн салбар	3,199	5,039	+1,840	+57.5%
Хүнсний салбар	1,981	2,663	+682	+34.4%
Нийт	5,180	7,702	+2,522	+48.7%

1.4.2.Ажилчдад төлсөн мөнгө (цалин)

Ажилчдад төлсөн мөнгө буюу цалин хөлсний дүнгийн тухайд хүнсний үйлдвэр 2022 онд 148.5 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 305.7 тэрбум төгрөгт, сав, баглаа

боодлын үйлдвэр 2022 онд 13.3 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 21.4 тэрбум төгрөгт, мал аж ахуйн салбарт 2022 онд 7.0 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 16.4 тэрбум төгрөгт, газар тариалангийн салбарт 2022 онд 29.1 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 70.5 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын ажилчдын цалинд төлсөн мөнгө 2 дахин, тухайлбал хөдөө аж ахуйн салбарт дунджаар 109 хувиар нэмэгдсэн бөгөөд хүнсний үйлдвэрийн салбарын ажилчдын цалинд төлсөн мөнгө нийт цалинд төлсөн мөнгөний 73 хувийг бүрдүүлж байна.

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	148.5	305.7	+157.2	+105.9%
Сав, баглаа боодлын үйлдвэр	13.3	21.4	+8.0	+60.2%
Мал аж ахуй	7.0	16.4	+9.4	+135.2%
Газар тариалан	29.1	70.5	+41.4	+142.1%
Нийт	197.9	414.0	+216.1	+109.2%

1.4.3. Нийгмийн даатгалд төлсөн мөнгө

Нийгмийн даатгалд төлсөн мөнгөний тухайд 2025 онд хүнсний үйлдвэр 94.4 тэрбум төгрөг, сав, баглаа боодлын үйлдвэр 6.5 тэрбум төгрөг, мал аж ахуйн салбарт 4.7 тэрбум төгрөг, газар тариалангийн салбарт 17.8 тэрбум төгрөгт тус тус хүрч, 2022 онтой харьцуулахад нийт дүнгээр 121 хувиар нэмэгдсэн байна.

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	41.9	94.4	+52.5	+125.1%
Сав, баглаа боодлын үйлдвэр	3.5	6.5	+3.1	+87.9%
Мал аж ахуй	2.0	4.7	+2.7	+139.1%
Газар тариалан	8.5	17.8	+9.3	+109.6%
Нийт	55.8	123.4	+67.5	+120.9%

1.4.4. Худалдан авалтад төлсөн мөнгө (бусдаас бараа, түүхий эд, материал, үйлчилгээ худалдан авах)

Бусдаас бараа, түүхий эд, материал, үйлчилгээ худалдан авалтад төлсөн мөнгөний тухайд 2025 онд хүнсний үйлдвэр 2,564.7 тэрбум төгрөг, сав, баглаа боодлын үйлдвэр 160.2 тэрбум төгрөг, мал аж ахуйн салбарт 100.6 тэрбум төгрөг, газар тариалангийн салбарт 734.5 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бөгөөд мал аж ахуйн салбарын худалдан авалт 2022 оноос 75 хувиар, хүнсний үйлдвэрийнх 2022 оноос 31 хувиар тус тус өссөн байна.

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	1,957.4	2,564.7	+607.4	+31.0%
Сав, баглаа боодлын үйлдвэр	148.0	160.2	+12.2	+8.2%
Мал аж ахуй	57.6	100.6	+43.0	+74.7%
Газар тариалан	559.4	734.5	+175.1	+31.3%
Нийт	2,722.3	3,560.0	+837.7	+30.8%

1.4.5. Татварт төлсөн мөнгө

Татварт төлсөн мөнгөний тухайд хүнсний үйлдвэр 2022 онд 75.5 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 143.6 тэрбум төгрөгт, мал аж ахуйн салбар 2022 онд 5.0 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 10.0 тэрбум төгрөгт, газар тариалангийн салбарт 2022 онд 24.3 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 33.3 тэрбум төгрөгт тус тус хүрч, мал аж ахуйн салбарын зээлдэгчийн татвар төлөлт 2 дахин, хүнсний үйлдвэрийн салбарынх 31 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин сав, баглаа боодлын үйлдвэр 2022 онд 16.6 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 15.3 тэрбум төгрөг болж 1.3 тэрбум төгрөгөөр буюу 8 хувиар буурсан байна.

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	75.5	143.6	+68.0	+90.1%
Сав, баглаа боодлын үйлдвэр	16.6	15.3	-1.3	-8.0%
Мал аж ахуй	5.0	10.0	+5.0	+100.7%
Газар тариалан	24.3	33.3	+9.0	+36.9%
Нийт	121.4	202.2	+80.7	+66.5%

1.4.6. Борлуулалтын орлого, нийт хөрөнгө, хөрөнгийн бүтэц

Хүнсний үйлдвэрийн борлуулалтын орлого 2022 онд 2,040.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 3,863.0 тэрбум төгрөгт, сав, баглаа боодлын үйлдвэрийнх 2022 онд 173.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 214.7 тэрбум төгрөгт, мал аж ахуйн салбарт 2022 онд 67.7 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 134.0 тэрбум төгрөгт, газар тариалангийн салбарт 2022 онд 710.0 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 951.2 тэрбум төгрөгт тус тус хүрч, нийт дүнгээр зээлдэгчийн борлуулалтын орлого 73 хувиар өссөн байна.

Тухайлбал мал аж ахуйн салбарт 98 хувь, хүнсний салбарт 89 хувийн өсөлттэй бөгөөд хэрэглээний үнээр зэрэгцүүлэхэд бодит борлуулалтын орлогын өсөлтийн 26 хувийг хүнс, хөдөө аж ахуйн салбар эзлэж байна.

Нийт хөрөнгийн тухайд хүнсний үйлдвэр 2022 онд 1,834.6 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 3,360.0 тэрбум төгрөгт, сав, баглаа боодлын үйлдвэр 2022 онд 143.7 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 250.7 тэрбум төгрөгт, мал аж ахуйн салбарт 2022 онд 129.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 243.1 тэрбум төгрөгт, газар тариалангийн салбарт 2022 онд 811.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 1,389.4 тэрбум төгрөгт тус тус хүрч, нийт хөрөнгө 80 хувиар өссөн байна.

Тухайлбал эргэлтийн бус хөрөнгө 2 дахин, эргэлтийн хөрөнгө 64 хувь, мал аж ахуйн салбар 98 хувь, хүнсний салбар 89 хувиар, тэр дундаа хүнсний салбарын эргэлтийн бус хөрөнгө хамгийн их буюу 121 хувиар өссөн нь хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилт их авсантай холбоотой байна.

а) Борлуулалтын орлого

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	2,040.2	3,863.0	+1,822.8	+89.3%
Сав, баглаа боодлын үйлдвэр	173.4	214.7	+41.3	+23.8%
Мал аж ахуй	67.7	134.0	+66.3	+98.0%
Газар тариалан	710.0	951.2	+241.2	+34.0%
Нийт	2,991.2	5,162.9	+2,171.7	+72.6%

б) Нийт хөрөнгө

Салбар	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Хүнсний үйлдвэр	1,834.6	3,360.3	+1,525.6	+83.2%
Сав, баглаа боодлын үйлдвэр	143.7	250.7	+107.0	+74.5%
Мал аж ахуй	129.2	243.1	+113.9	+88.2%
Газар тариалан	811.2	1,389.4	+578.1	+71.3%
Нийт	2,918.7	5,243.4	+2,324.7	+79.6%

в) Хөрөнгийн бүтэц (нийт дүнгээр)

Үзүүлэлт	2022 он	2025 он	Өөрчлөлт	Өсөлт, %
Эргэлтийн хөрөнгө	1,723.8	2,819.3	+1,095.5	+63.6%
дотор: Эргэлтийн бус хөрөнгө	1,194.9	2,424.1	+1,229.2	+102.9%
Нийт хөрөнгө	2,918.7	5,243.4	+2,324.7	+79.6%

ХОЁР.“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ХҮРЭЭНД ОЛГОСОН ЗЭЭЛ

2.1.Хоршооны гишүүн малчны зээлийн хэрэгжилт:

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай” Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол, “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 167 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Зээлийн батлан даалтын сан болон арилжааны 8 банкны хамтран баталсан санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу арилжааны банкны эх үүсвэрээр жилийн 6 хувийн хүүтэй, 3-5 жилийн хугацаатай нийт 894.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг хоршооны гишүүн 26,438 малчинд олгосон бөгөөд энэхүү зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хэмжээ 12.0 нэгж хувь болно.

2.2.Хоршооны гишүүн малчны зээл олголт, улсын төсвөөс хариуцан төлсөн хүүгийн дэмжлэгийн гүйцэтгэл:

Хөрөнгө оруулалтын зээлийн зориулалт:

№	Зээлийн зориулалт, ангилал	Нийт олгосон		Малчны тоо
		Зээлийн дүн	Эзлэх хувь	
1	Бэлчээрт худаг, уст цэг гаргах, усан хангамж байгуулах	16.32	1.8%	453
2	Бүх төрлийн тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	47.02	5.3%	1343
3	Мал бордох аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	45.32	5.1%	1295
4	Мах, сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	62.69	7.0%	1848

/тэрбум төгрөг/

5	Үржлийн мал худалдан бойжуулах, борлуулах	512.80	57.3%	15335
6	Ноос, ноолуур, арьс шир бэлтгэх, анхан шатны тордолт хийх цэг, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	6.00	0.7%	186
7	Дотор мах боловсруулах үйлдвэр, цех байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	3.06	0.3%	86
8	Мал, малын гаралтай түүхий эдийн агуулах, зоорь, хөргүүр байгуулах	24.92	2.8%	682
9	Мал төхөөрөх цех, үйлдвэр байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	7.26	0.8%	210
10	Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх	22.64	2.5%	703
11	Мал эмнэлгийн ажил, үйлчилгээ	2.03	0.2%	57
12	Мал аж ахуйн үйлдвэрлэлд зориулагдсан малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник, тоног төхөөрөмжийн дундын үйлчилгээ үзүүлэх, технологи нэвтрүүлэх	42.56	4.8%	1171
13	Гахай, шувуу, зөгий, цаа буга зэрэг ашиг шимийг нь тогтмол хүртдэг тэжээвэр амьтны аж ахуй байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх	7.21	0.8%	217
14	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийн зориулалттай барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, (автомашин), тоног төхөөрөмж худалдан авах	95.00	10.6%	2852
	Нийт дүн	894.83	100%	26438

Улсын төсвөөс зээлийн хүүгийн хөнгөлөлтөд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл:

/тэрбум/төгрөг/

Татаас	2024 он			2025 он			2026 оны 06 сар		
	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
Хоршооны гишүүн малчны зээл	25.2	25.1	100%	105.3	59.4	56%	75.9	62.8	83%

2026 оны хагас жилийн байдлаар нийт зээлийн үлдэгдэл 702.2 тэрбум төгрөг байгаа бөгөөд хүүгийн дэмжлэгт 2024 онд 25.1 тэрбум төгрөг, 2025 онд 59.4 тэрбум төгрөг, 2026 оны хагас жилийн байдлаар 62.8 тэрбум төгрөг буюу нийт 147.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгоод байна.

Улсын Их Хурлын ерөнхий хяналтын сонсголын хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай” Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх товч мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн ХЭГ/3016 дугаартай албан бичгээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлсэн болно.

ГУРАВ. “ЦАГААН АЛТ” ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ОЛГОСОН ЗЭЭЛ

3.1. “Цагаан алт” хөдөлгөөний зээлийн хэрэгжилт:

"Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолоор "Цагаан алт" хөдөлгөөнийг өрнүүлэхээр шийдвэрлэж, уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

Засгийн газрын 2024 оын 190 дүгээр тогтоолоор "Цагаан алт" хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгийг Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан тооцохоор шийдвэрлэсэн бөгөөд ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч болон арилжааны 9 банкны хамтран баталсан санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу арилжааны банкны эх үүсвэрээр Засгийн газраас хариуцах төлөх хүүгийн хэмжээ 9-10 хувь, 2-4 жилийн хугацаатай нийт 961.0 тэрбум төгрөгийн зээлийг 256 зээлдэгчид олгосон. Нийт олгосон зээлийн 86.8 хувь буюу 834.4 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгийн, 13.2 хувь буюу 126.6 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын чиглэлийн зээл байна.

3.2."Цагаан алт" хөдөлгөөний зээл олголт, улсын төсвөөс хариуцан төлсөн хүүгийн дэмжлэгийн гүйцэтгэл:

№	Зээлийн зориулалт, ангилал	/тэрбум төгрөг/					
		2025 он		2026.06 сар		Нийт дүн	
		Олгосон дүн	ААН-ийн тоо	Олгосон дүн	ААН-ийн тоо	Олгосон дүн	ААН-ийн тоо
1	Ноолуур боловсруулах үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгө	325.0	73	440.6	70	765.65	143
2	Ноос, хөөвөр боловсруулах үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгө	30.2	24	10.2	2	40.40	26
3	Арьс шир боловсруулах үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгө	12.1	7	1.2	2	13.29	9
4	Савхин гутал, савхи болон нэхий хувцас, цүнх, жижиг эдлэл, бүс тэлээ, савхин бээлийний үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн эргэлтийн хөрөнгө	15.1	16			15.10	16
	Нийт эргэлтийн хөрөнгийн зээл	382.4	120	452.0	74	834.44	194
5	Ноолуурын ээрэх үйлдвэрлэл	14.4	3			14.40	3
6	Ноолуурын сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах үйлдвэрлэл	26.2	15			26.20	15
7	Ноос самнах /хялгас ялгах/ үйлдвэрлэл	12.8	7			12.80	7
8	Ноос ээрэх үйлдвэрлэл	8.5	5			8.50	5
9	Ноос сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах үйлдвэрлэл	29.1	14			29.10	14

10	Ноосон дулаалга, эдлэл, бордооны үйлдвэрлэл	0.8	2			0.80	2
11	Арьс шир боловсруулах үйлдвэрлэл	2.6	2			2.60	2
12	Савхин гутал, хувцас болон нэхий хувцас, цүнх, жижиг эдлэл, бүс тэлээ, савхин бээлий үйлдвэрлэл	12.8	11			12.80	11
13	Арьс ширний үйлдвэрлэлээс гарч буй технологийн хаягдал болон уургийн гаралтай хаягдлыг боловсруулах үйлдвэрлэл	19.4	3			19.40	3
	Нийт хөрөнгө оруулалтын зээл	126.6	62	-	-	126.60	62
	Нийт зээлийн дүн	509.0	182	452	74	961.04	256

Улсын төсвөөс зээлийн хүүгийн хөнгөлөлтөд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл:

/тэрбум төгрөг/

Татаас	2025 он			2026 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
"Цагаан алт" хөдөлгөөний зээл	66.3	15.7	24%	75.1	31.8	42%

Зээлийн хүүгийн дэмжлэгт 2025 онд 15.7 тэрбум төгрөг, 2026 оны хагас жилийн байдлаар 31.8 тэрбум төгрөг буюу нийт 47.5 тэрбум төгрөг улсын төсвөөс олгосон.

3.3. "Цагаан алт" хөдөлгөөний зээлийн үр дүн, хүрсэн түвшний үзүүлэлт:

3.3.1. 2025 оны үр дүн:

Ноолуурын үйлдвэрлэлийн салбарт:

Эргэлтийн хөрөнгө: "Цагаан алт" хөдөлгөөний үр дүнд 46 аж ахуйн нэгжид 327.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 6,000 тонн бохир ноолуур бэлтгэсэн нь анх удаа түүхий эдийн 70 орчим хувийг эзэлж байна.

Вексель: Түүхий эд бэлтгэн авах, ноолууран түүхий эдийн үнийг унагахгүй тогтвортойгоор барих, үйлдвэрлэлээ тасралтгүй амжилттай явуулж, ноолуур бэлтгэлийн цаг үеийн байдлыг эрсдэл багатайгаар даван туулах хүрээнд Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар ноолуурын худалдан авалтыг дэмжиж, жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Монголбанканд зөвлөсөн. Энэ хүрээнд Монголбанк, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК дөрвөлсөн гэрээг Хаан банк, Голомт банк, "Говь" ХК, "Ханбогдкашемир" ХХК-тай тус тус байгуулсан бөгөөд "Говь" ХК нь Говь-Алтай аймгийн 2, Баянхонгор аймгийн 1 хоршооны нийт 27 малчнаас 7.0 тэрбум төгрөгийн ноолуур худалдан авч векселиэр төлсөн.

Ноолуурын салбарт вексель гаргаснаар хөдөө аж ахуйн салбарт санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн шинэлэг арга хэмжээ болсон.

Хөрөнгө оруулалт: Ээрэхийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 15.6 тэрбум төгрөгийн зээл олгосон нь ээрэх хүчин чадлыг 400 тонн, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 33.7 тэрбум төгрөгийн зээл олгосон нь сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхгээр тус тус нэмэгдүүлсэн.

Ноосны үйлдвэрлэлийн салбарт:

Эргэлтийн хөрөнгө: Ноосны эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 23 аж ахуйн нэгж 30.2 тэрбум төгрөгийн зээл авсан. Зээлийн болон дотоодын эх үүсвэрээр 5.5 тонн хонины ноос, 88 тонн тэмээний ноос, 143.1 тонн сарлагийн хөөвөр, 422 тонн угаасан хонины ноос, 30.3 тонн самнасан хонины ноос, 10 тонн самнасан сарлагийн хөөвөр, 272.1 тонн хонины ноосон ээрмэл утас худалдан авсан байна.

Хөрөнгө оруулалт: Ээрэхийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 8.5 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хүчин чадлыг 300 тонн, хялгас ялгахын хөрөнгө оруулалтын зориулалтаар 14.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хүчин чадлыг 530 тонн, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 29.1 тэрбум төгрөгийн зээл олгосон нь нэхэх /хивс/ хүчин чадлыг 200 мянган м.кв, сүлжих хүчин чадлыг 50 мянган ширхгээр, ноосон дулаалгын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 800 сая төгрөгийн зээл олгосон нь ноосон дулаалгын материал үйлдвэрлэлийг 3 мянган м.кв-аар тус тус нэмэгдүүлсэн.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт:

Эргэлтийн хөрөнгө: Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 22 аж ахуйн нэгжид 26.7 тэрбум төгрөгийн зээл олгож, 1.2 сая ширхэг бог, 488.5 мянган ширхэг бодын шир бэлтгэх боломжийг бүрдүүлсэн.

Хөрөнгө оруулалт: Арьс ширний гүн боловсруулах үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 2.6 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хүчин чадлыг 500 мянган ширхэг, гутал үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 12.8 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хүчин чадлыг 550 мянган хос, желатины үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 19.4 тэрбум төгрөгийн зээл олгосон нь 1.06 мянган тонн желатин үйлдвэрлэх хүчин чадлаар тус тус нэмэгдүүлсэн.

3.3.2.2026 оны үр дүн

2026 онд ноолуурын үйлдвэрлэлд 450.0 тэрбум, ноосны үйлдвэрлэлд 50.0 тэрбум, арьс ширний үйлдвэрлэлд 35.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгохоор арилжааны 6 банктэй гэрээ байгуулсан.

2026 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ноолуурын эргэлтийн хөрөнгийн 439.7 тэрбум төгрөгийн зээл гарч 68 хяналтын гэрээ, ноосны эргэлтийн хөрөнгийн 18.0 тэрбум төгрөгийн зээл гарч 6 хяналтын гэрээ, арьс ширний эргэлтийн хөрөнгийн 4.7

тэрбум төгрөгийн зээл гарч 4 хяналтын гэрээ, нийт 462.4 тэрбум төгрөгийн 78 зээлийн хяналтын гэрээг байгуулаад байна.

№	Зээлийн зориулалт	2026.08.28, тэрбум төгрөг	Хяналтын гэрээ
	Нийт зээлийн санхүүжилт	462.4	78
1.1	Ноолуурын эргэлтийн хөрөнгө	439.7	68
1.2	Ноосны эргэлтийн хөрөнгө	18.0	6
1.3	Арьс ширний эргэлтийн хөрөнгө	4.7	4

Ноолуурын үйлдвэрлэлийн салбарт:

Эргэлтийн хөрөнгө: "Цагаан алт" хөдөлгөөний үр дүнд ноолуурын үйлдвэрлэлийн салбарт хөнгөлөлттэй зээл болон өөрсдийн дотоод эх үүсвэрээр 4,800 тонн ноолуур бэлтгэсэн буюу түүхий эдийн 60 орчим хувийг дотоодын үйлдвэрлэгч нар бэлтгэсэн байна.

Ноолуурын дуудлага худалдаа:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, Монголын ноос ноолуурын холбоо хамтран "Монгол ноолуур-2026" ноолуурын дуудлага худалдаа арга хэмжээг 2026 оны 03 дугаар сард Сүхбаатар аймагт зохион байгуулсан.

Дуудлага худалдаанд үндэсний томоохон үйлдвэрлэгч болох Говь, Кашмерхолдингс, Ханбогдкашмер, Хатант-Интернэшнл, Соркашемир, Капрадоро, Гоёлкашмер, Говь-Айгар, Баялаг-Өлзий, Лоропьяна, Холчжинчин, Түмэн сүлжээ компаниуд оролцож, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн ноолуурыг 191.5-198.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, малчид, хоршоодоос чанар, стандартын шаардлага хангасан ноолуурыг үндэсний үйлдвэрлэгчид дундын зуучлалгүй, ил тод, нээлттэйгээр худалдан авсан нь дуудлага худалдааны гол онцлог байсан.

"Арьс шир баялаг" хөтөлбөр:

"Арьс шир баялаг" хөтөлбөрийн хүрээнд Архангай, Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн нийт 39 мах боловсруулах болон мал нядалгааны үйлдвэр, хоршоотой арьс шир бэлтгэх гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд нийт 4,595 ширхэг арьс шир давсалж бэлтгэсэн бөгөөд "Мон-Ирээдүй" ХХК 500 ширхэг үхрийн шир, "Булигаар" ХК 800 ширхэг үхрийн ширийг тус тус худалдан аваад байна.

ДӨРӨВ. "АТАР-4 ТАРИАЛАНГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АЯН"-Ы ХҮРЭЭНД ОЛГОСОН ЗЭЭЛ

4.1. "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы зээлийн хэрэгжилт:

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжүүлэх зорилгоор “Аян өрнүүлэх тухай” Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд газар тариалан, мал аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр тариалан эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Нийт 616.5 тэрбум төгрөгийн зээлийг 1,498 зээлдэгчид 2-4 жилийн хугацаатай олгосон. Энэхүү зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хэмжээ 10.0 нэгж хувь бөгөөд зээлийн хүүгийн дэмжлэгт 2025 онд 2,817.45 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон.

4.2.“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы зээлийн олголт, улсын төсвөөс хариуцан төлсөн хүүгийн дэмжлэгийн гүйцэтгэл:

№	Зээлийн зориулалт	/тэрбум төгрөг/					
		2025 он		2026.06 сар		Нийт дүн	
		Олгосон дүн	Зээлийн тоо	Олгосон дүн	Зээлийн тоо	Олгосон дүн	Зээлийн тоо
	Эргэлтийн хөрөнгийн зээл	294.47	598	138.94	906	433.41	1,504
1	Үр тариа, тос, тэжээлийн таримлын үйлдвэрлэлийг дэмжих	79.41	270	89.78	401	169.19	671
2	Үр тариа, төмс, хүнсний ногооны үр үйлдвэрлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	-	-	7.96	36	7.96	36
3	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	-	-	35.24	412	35.24	412
4	Хүлэмжийн аж ахуй, мөөгний үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	-	-	4.22	36	4.22	36
5	Жимс, жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	-	-	1.74	21	1.74	21
6	Төмс, хүнсний ногоо, мөөг, жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийг дэмжих	28.22	247	-	-	28.22	247
7	Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн диллерүүдийг дэмжих	35.82	13	-	-	35.82	13
8	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхэр авах	20.70	25	-	-	20.70	25
9	Гурил, тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авах	111.31	14	-	-	111.31	14
10	Сүү боловсруулах үйлдвэрийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих	11.61	20	-	-	11.61	20
11	Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл	7.40	9	-	-	7.40	9

	ажлыг хангах хүрээнд малчдаас мал, мах худалдан авах						
	Хөрөнгө оруулалтын зээл	322.01	384	8.27	45	330.28	429
12	Иж бүрэн механикжсан үтрэм байгуулах	6.83	16	-	-	6.83	16
13	Төмс, хүнсний ногооны механикжсан агуулах, зоорь шинээр байгуулах	27.76	50	2.17	22	29.93	72
14	Хүлэмжийн аж ахуй, ургамлын үйлдвэр шинээр байгуулах	6.68	15	4.78	6	11.45	21
15	Услалтын систем			1.32	17	1.32	17
16	Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж авах	30.63	87	-	-	30.63	87
17	Мөөгний үйлдвэр байгуулах, өргөжүүлэх	0.50	1	-	-	0.50	1
18	Махны үхрийн аж ахуй өргөтгөх, байгуулах	19.85	30	-	-	19.85	30
19	Өсвөр мал бордох аж ахуйгаа өргөтгөх	9.80	23	-	-	9.80	23
20	Шувууны аж ахуйн үйл ажиллагаагаа тогтворжуулах	11.44	11	-	-	11.44	11
21	Тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	15.04	9	-	-	15.04	9
22	Зөгийн аж ахуйн үйл ажиллагааг дэмжих	1.87	23	-	-	1.87	23
23	Сүүний үхрийн аж ахуй (кластер) байгуулах	28.23	25	-	-	28.23	25
24	Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	73.34	36	-	-	73.34	36
25	Үр тарианы гаралтай боловсруулах үйлдвэр байгуулах	3.96	3	-	-	3.96	3
26	Хүнсний худалдаа, махны агуулах шинээр байгуулах, өргөтгөх, тоног төхөөрөмжийн зээл	68.18	43	-	-	68.18	43
27	Сав, баглаа боодлын үйлдвэр шинээр байгуулах, өргөтгөх	17.90	12	-	-	17.90	12
	Нийт олгосон зээлийн дүн	616.48	982	147.21	951	763.70	1,933

Улсын төсвөөс зээлийн хүүгийн хөнгөлөлтөд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл:
/тэрбум төгрөг/

Татаас	2025 он			2026 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
"Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы зээл	52.8	2.8	5%	60.3	34.8	58%

Зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2025 онд 2.8 тэрбум төгрөг, 2026 оны хагас жилийн байдлаар 34.8 тэрбум төгрөг, нийт 37.6 тэрбум төгрөг улсын төсвөөс олгосон.

4.3."Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы зээлийн үр дүн, хүрсэн түвшний үзүүлэлт:

“Аян өрнүүлэх тухай” Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд газар тариалан, мал аж ахуй, хүнсний боловсруулах үйлдвэрийн уялдаа холбоог бэхжүүлэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгож, Засгийн газраас зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

2025 оны үр дүн:

Монголбанкны 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн мэдээллээр нийт 982 зээлдэгчид 616.48 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Үүнээс газар тариалангийн салбарт 215.8 тэрбум төгрөг, мал аж ахуйн салбарт 114.3 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах үйлдвэрийн салбарт 268.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Тодруулбал, газар тариалан, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 598 иргэн, аж ахуйн нэгжид 294.4 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 384 иргэн, аж ахуйн нэгжид 322.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон байна. Үүнээс газар тариалангийн салбарт 530 иргэн, аж ахуйн нэгжид 143.4 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 169 иргэн, аж ахуйн нэгжид 72.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл олгосон. Ингэснээр хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгааллын ажил, ургац хураалтын бэлтгэлийг технологийн хугацаанд гүйцэтгэх боломж бүрдэж, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл эрчимжсэн.

Зээлийн дэмжлэгийн үр дүнд 2025 онд улсын хэмжээнд 601.6 мянган га талбайд тариалалт хийж, 881 мянган тонн ургац хураан авсан байна. Үүнд 267.5 мянган тонн улаанбуудай, 114.1 мянган тонн төмс, 239.7 мянган тонн хүнсний ногоо, 198.2 мянган тонн малын тэжээл, 34 мянган тонн тосны ургамал хураан авсан. Өмнөх жилүүдтэй харьцуулахад хүнсний ногоо болон тосны ургамлын үйлдвэрлэл өссөн бөгөөд Монгол Улс дотоодын хэрэгцээт улаанбуудайн 62.5 хувь, төмсний 76.9 хувь, хүнсний ногооны 72.6 хувийг хангах боломжийг бүрдүүлжээ.

Түүнчлэн тариалангийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэн төмс, хүнсний ногооны механикжсан зоорийн багтаамж 20 хувиар буюу 50 мянган тонн, анхан шатны үтрэмийн багтаамж 13 хувиар буюу 67 мянган тонн, хүлэмж 28 хувиар буюу 34.5 га-аар тус тус нэмэгдсэн.

2026 оны үр дүн:

Аяны хүрээнд хөрсний үржил шимийг хамгаалах, усалгаатай тариаланг өргөжүүлэх, үр сортын шинэчлэл хийх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүсчилсэн хөгжлийг дэмжих чиглэлээр арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй, арилжааны банкны эх үүсвэр бүхий хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэж, арилжааны 7 банктай

санхүүжилтийн гэрээг дахин байгуулж, хөрөнгө оруулалтын зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн.

Арилжааны банкны 2026 оны 08 дугаар сарын мэдээгээр нийт 951 иргэн, аж ахуйн нэгжид 147.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Үүнээс 906 иргэн, аж ахуйн нэгжид 138.8 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 45 иргэн, аж ахуй нэгжид 8.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийг олгосноор техник, технологийн шинэчлэл хийгдэж, хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

Энэхүү үр дүнд 2026 онд улсын хэмжээгээр 580.4 мянган га талбайд тариалж, 555.3 мянган тонн үр тариа, үүнээс 497.1 мянган тонн улаанбуудай, мөн 168.2 мянган тонн төмс, 218.4 мянган тонн хүнсний ногоо, 50.4 мянган тонн тосны ургамал, 201.8 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авах төлөвтэй байгаа бөгөөд дотоодын үйлдвэрлэлээр улаанбуудай, төмсийг 100 хувь, хүнсний ногооны 70 орчим хувийг хангах нөхцөл бүрдэж байна.

Түүнчлэн тариалангийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэн төмс, хүнсний ногооны механикжсан зоорийн багтаамж 26 мянган тонн, өвлийн хүлэмж 2,600 м2 га-аар тус тус нэмэгдээд байна. Энэ жилийн тухайд ургац хураалтад нийтдээ 951 комбайн, 609 ширхэг жатка, 230 үтрэмд 1,058 ширхэг үр тариа цэвэрлэх тоног төхөөрөмж, 453 ширхэг төмс, хүнсний ногоо хураах тоног төхөөрөмж ажиллах бөгөөд техник засварын ажил 82 хувьтай явагдаж байна. Ургац хураалтад ажиллах техникийн иж бүрдлээр тооцоход хураалтын ажлыг 26-30 хоногт багтаан дуусгах техникийн боломж бүрдсэн байна.

“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд хэрэгжүүлсэн зээлийн үр дүн нь тариалангийн үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулах, техник технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэлийг өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ
ХЭРЭГЖИЖ БУЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛООР БАТАЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, АЯНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 ОН**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ
ХЭРЭГЖИЖ БУЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛООР БАТАЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, АЯНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

2026 оны 06 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Нэг.Хяналт -шинжилгээний зорилго

1.1.Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36, Улсын Их Хурлын түр хорооны 2023 оны 02, Улсын Их Хурлын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63, Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо-чинээлэг малчин" 166 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хэрэгжилтэд 2026 оны 06 сарын байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах.

Хоёр.Арга зүй

2.1.Улсын Их Хурлын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36, Улсын Их Хурлын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63, Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо-чинээлэг малчин" 166 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам"-ын 6.8-д "Улсын Их Хурлын тогтоолын хавсралтаар баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн шазрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"...- аар хяналт, шинжилгээ, үнэлнэ" гэж заасны дагуу тус журмаар хяналт -шинжилгээ хийхэд тус журамд зааснаар хэрэгжилтийн явц, үр дүнг шууд томъёогоор тооцож, хувиар илэрхийлэх боломжгүй байх тул арга хэмжээний төлөвлөгөө, аяны хэрэгжилтийн хувийг тооцсон.

Гурав. Хэрэгжилт

3.1. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Тус тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5 чиглэлд хамаарах нийт 114 арга хэмжээний хэрэгжилт 80.29%-тай байна.Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 18 арга хэмжээнээс 12 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 4 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50- 70%, 1 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%, 1 арга хэмжээ хугацаа болоогүй буюу дундаж биелэлт 87.65%.

Энэ хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Батлагдсан хууль:

- Хөдөө аж ахуйн тухай хууль
- Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль,
- Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,
- Төрийн хяналт, шалгалтын тухай,

Баталсан журам, аргачлал, төлөвлөгөө, удирдамж, стандарт:

- Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам
- Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал

- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм
- Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам
- Мах, махан бүтээгдэхүүнд хийх мал эмнэлгийн эмийн үлдэц, бохирдуулагч бодисын хяналт шинжилгээний удирдамж,
- Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл жиллагааны төлөвлөгөө
- Нийт 2 техникийн зохицуулалт, 24 стандартын шинэчилсэн.
УИХ-д өргөн барьсан хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (хүнсний давстай холбоотой заалтуудыг тусгасан)
Үзэл баримтлал нь батлагдсан хууль, тогтоол
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль
- “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Боловсруулах шатанд байгаа хууль
- Тариалангийн даатгалын тухай (хугацаа болоогүй)
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
Боловсруулах шатанд журам
- Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам

2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 17 арга хэмжээнээс 14 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%, 1 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 92.35%.

3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 25 арга хэмжээнээс 13 арга хэмжээ үр дүнтэй буюу 90-100%, 5 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50-70%, 7 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 10-40% буюу дундаж биелэлт 68.66%.

4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 21 арга хэмжээнээс 10 арга хэмжээ үр дүнтэй буюу 90-100%, 6 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50-80%, 2 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%, 3 арга хэмжээ үр дүнгүй буюу 0-5% буюу дундаж биелэлт 69.48%.

5. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 33 арга хэмжээнээс 24 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 3 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%, 4 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-40%, 2 арга хэмжээ үр дүнгүй буюу 0-10% буюу дундаж биелэлт 83.3%.

Тайлант хугацааны тус тогтоолын хэрэгжилтээс харахад “0-10” хувийн үнэлгээтэй дараах арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээ	0-10% үнэлэгдсэн шалтгаан
1	3.3.3. Бага оврын тоног төхөөрөмж, ажлын эд ангиудыг үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Монгол Улсад Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгтэйгээр трактор угсрах үйлдвэр байгуулах тохиролцоонд хүрсэн төдий байгаа нь төлөвлөлтийг тооцоо судалгаатай хийгээгүй.
2	3.10.1.Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах	Улсын хэмжээнд 250.8 км ойн зурвас байгуулагдсан ч зорилтот түвшинг хэт өндрөөр төлөвлөсөн. Төлөвлөлтийг тооцоо судалгаатай хийгээгүй. (2500 км ойн зурвасыг шинээр байгуулсан байх)
3	3.10.4. Аймаг, суманд агро ойн аж ахуйг байгуулж, хүнсний хангамжийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх	Нийт 3 байршилд 140 га талбайд агро ойн аж ахуй байгуулан 94.4 мянган модыг тарьж арчлан ургуулсан боловч зорилтот түвшинд хүрээгүй. Зорилтот түвшинг хэт өндрөөр төлөвлөсөн. Төлөвлөлтийг тооцоо судалгаатай хийгээгүй. (Зорилтот түвшин 150 агро аж ахуй байгуулахаар төлөвлөсөн.)
4	4.1.3. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлэх, хариу арга хэмжээг авах	Санхүүжилт батлагдаагүй тул тус арга хэмжээ хэрэгжээгүй.
5	4.3.1. Хот, суурин болон тариалангийн бүс нутагт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйд дэмжлэг үзүүлэх	Өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн үхрийн тоо 360 толгойгоор нэмэгдэж зорилтод түвшиний 5%-д хүрсэн. Зорилтот түвшинг хэт өндрөөр төлөвлөсөн. Төлөвлөлтийг тооцоо судалгаатай хийгээгүй. (Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 5.0 мянга, махны чиглэлийн цэвэр үүлдрийн 4.0 мянган толгой үхэр импортлохоор төлөвлөсөн)
6	4.4.1. Гахайн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	Зээл олгодоогүй. Зээл хүсэгчид банкны шаардлагад нийцээгүй.
7	5.4.1. Хоногт 20.0 мянган литр шингэн сүүг боловсруулж, хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	тухайн зээлийн арга хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамрагдах хүсэлт гаргаагүй байна.
8	5.4.3. Төмс боловсруулж цардуул, төмсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	Цардуулын үйлдвэрийн төслийг танилцуулсан боловч тухайн арга хэмжээнд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж хүсэлт гаргаагүй.

УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 3160 (давхардсан тоогоор) зээлдэгчид 1261.43 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг олгож, 2026 оны хагас жилийн байдлаар зээлийн хүүгийн хөнгөлөлтөд нийт 264.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

3.2."Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Тус тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4 чиглэлд хамаарах нийт 27 арга хэмжээний хэрэгжилт 53.66%-тай байна.Үүнд:

1. Салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 5 арга хэмжээнээс 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%, 3 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 40%.

Энэ хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийгдсэн хууль

- Хөнгөн үйлдвэрлэлийн тухай анхдагч хууль

Өөрчлөлт оруулсан стандарт

- MNS 0037:2007 "Ноос, ноолуур. Хялгас. Техникийн шаардлага",

- MNS 4251:2008 "Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал, сэв хялгас, богино ноолуур. Техникийн шаардлага"

Боловсруулах шатанд байгаа хууль

- "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бүтээгдэхүүний тухай" хуулийн шинэчилсэн найруулга

2. Түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 8 арга хэмжээнээс 2 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 4 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50-70%, 2 арга хэмжээ 0% буюу дундаж биелэлт 57.5%.

3. Үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 11 арга хэмжээнээс 3 арга хэмжээ үр дүнтэй буюу 89-100%, 3 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50-70%, 5 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 54.45%.

4. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах чиглэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 3 арга хэмжээнээс 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%, 1 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 56.67%.

Тайлант хугацааны тус тогтоолын хэрэгжилтээс харахад "0" хувийн үнэлгээтэй дараах арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээ	0% үнэлэгдсэн шалтгаан
1	2.3.1. Хөдөө аж ахуйн биржийн худалдааг зах зээлийн зохион байгуулалтад шилжүүлэх, түүхий эдийн чанар, стандартыг сайжруулах, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх	Төсөв хөрөнгө шийдэгдээгүй
2	2.5.1. Дотоодын баталгаажуулалтыг олон улсын хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар давхар баталгаажуулалт /магадлан итгэмжлэл/ хийлгэх	Арга хэмжээг хэрэгжүүлснээр гарах эерэг үр дүнг хэмжих шалгуурыг оновчтой тодорхойлоогүй.

УИХ-ын 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 оны хагас жилийн байдлаар нийт 170 зээлдэгчид 486.1 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2025 онд 15.6 тэрбум, 2026 оны хагас жилийн байдлаар 31.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

3.3. Засгийн газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы хэрэгжилт:

Тус тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн 5 зорилт, 12 дэд зорилтын хүрээн дэх нийт 67 арга хэмжээний хэрэгжилт 50.7%-тай байна. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгальд ээлтэй тариалангийн үйлдвэрлэл:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 3 дэд зорилтын 20 арга хэмжээнээс 7 арга хэмжээ үр дүнтэй буюу 90-100%, 7 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50-70%, 5 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%, 1 арга хэмжээ 0% буюу дундаж биелэлт 60%.

2. Бүсчилсэн хөгжил:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 2 дэд зорилтын 8 арга хэмжээнээс 2 арга хэмжээ үр дүнтэй буюу 90-100%, 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50%, 4 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-42.2% буюу дундаж биелэлт 52.8%.

3. Үйлдвэрлэлийн бүтээмж, үнэ цэнийн сүлжээ:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 2 дэд зорилтын 16 арга хэмжээнээс 5 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 1 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50%, 6 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%, 4 арга хэмжээ 0-3% буюу дундаж биелэлт 45.8%.

4. Шинжлэх ухаан, технологи:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 3 дэд зорилтын 16 арга хэмжээнээс 3 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50%, 7 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%, 4 арга хэмжээ 10-11.5% буюу дундаж биелэлт 40.7%.

5. Эрсдэлийн тогтолцоо, гадаад хамтын ажиллагаа:

Тус зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 2 дэд зорилтын 7 арга хэмжээнээс 2 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 2 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 50%, 3 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 56.7%.

Тайлант хугацааны тус тогтоолын хэрэгжилтээс харахад "0-11.5" хувийн үнэлгээтэй дараах арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга/хэмжээ	0-11.5% үнэлэгдсэн шалтгаан
1	1.1.7 Тариалангийн хохирол тооцох, ургац тогтоох журмыг шинэчлэн, цахим тогтолцоог бүрдүүлэх	Зохион байгуулалтаас
2	3.1.8 Импорт орлох яст болон үрт жимсний (алим, лийр, тоор, чавга зэрэг) эх цэцэрлэг, үржүүлгийн загвар Агро-ойн аж ахуй байгуулах	Одоогийн байдлаар уг зээлийн зориулалтын дагуу 20 зээлдэгч 1,65 тэрбум төгрөгийн зээлийг авч 1.5 мянган га-д жимс, жимсгэнэ тариалаад байгаа боловч зорилтот түвшинд хүрээгүй.
3	3.2.1 Бүс нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, ангилах, савлах логистикийн төвүүдийг байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	Санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй.
4	3.2.2 Газар тариалангийн бүтээгдэхүүнийг цэвэрлэх, боловсруулах, ялгах, савлах, хатаах, хөлдөөх боловсруулах үйлдвэр, цехүүдийг байгуулахад зээлийн дэмжлэг үзүүлэх	Санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй
5	3.2.3 Хөргөлтийн систем, вакум савлагаа, орчин үеийн техник, технологи бүхий төмс, хүнсний ногооны механикжсан агуулах, зоорь байгуулахад зээлийн дэмжлэг үзүүлэх	Санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй
6	4.1.3 Төмсний вирусгүй бичил булцууг үйлдвэрлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	Вирусгүй бичил булцуу үржүүлэх лаборатори ашиглалтад орж, жилд 40.0-50.0 мянган ширхэг бичил булцуу үйлдвэрлэх хүчин чадал бүрдсэн. 2026 оны эхний хагас жилийн байдлаар 12.7 мянган ширхэг вирусгүй бичил булцуу үржүүлсэн. Зорилтот түвшинд хүрээгүй.
7	4.2.5 Монгол орны төв, зүүн, говийн бүс нутгуудад жимс жимсгэнийн тариалан эрхлэх газрын тохиромжтой байдлын үнэлгээний судалгаа хийх	Бэлтгэл ажил хийгдэж зорилтот түвшинд хүрээгүй
8	4.3.5 "Хотоос хөдөөд" санаачилгыг дэмжих, залуучуудыг орон нутагт ажиллах боломжийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хөдөө аж ахуйн салбарын ерөнхий ойлголтыг тусгах, хүүхдүүдэд сурталчлан таниулах	Төлөвлөлтийн түвшинд зорилтот түвшинд хүрээгүй.

ЗГ-ын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 оны хагас жилийн байдлаар нийт 896 зээлдэгчид 481.2 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2025 онд 2.8 тэрбум, 2026 оны хагас жилийн байдлаар 34.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

3.4. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо-чинээлэг малчин" 166 дугаар тогтоолын хэрэгжилт:

Тус тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөсөн 2 чиглэлийн нийт 13 арга хэмжээний хэрэгжилт 86.92%-тай байна.Үүнд:

1. Хоршооны гишүүн малчинд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх:

Тус чиглэлийн хүрээнд төлөвлөгдсөн 4 арга хэмжээнээс 3 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 1 арга хэмжээ 0% буюу дундаж биелэлт 75%.

2. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг идэвхжүүлэх, сурталчлах:

Тус чиглэлийн хүрээнд төлөвлөгдсөн 9 арга хэмжээнээс 8 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 1 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% буюу дундаж биелэлт 92.2%.

Тайлант хугацааны тус тогтоолын хэрэгжилтээс харахад "0" хувийн үнэлгээтэй дараах арга хэмжээ байна. Үүнд:

№	Арга хэмжээ	0% үнэлэгдсэн шалтгаан
1	1.4 Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлэх	Сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлээгүйгээс эрсдэлийн санг бэхжүүлэх боломж хязгаарлагдаж, цаашдын үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн.

ЗГ-ын 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2026 оны хагас жилийн байдлаар нийт 28880 зээлдэгчид 873 тэрбум төгрөгийн зээлийг олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 2025 онд 59.4 тэрбум, 2026 оны хагас жилийн байдлаар 62.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

Дөрөв.Дүгнэлт

4.1."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын 5 чиглэлд хамаарах нийт 114 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 2026 оны хагас жилийн байдлаар 80.29%-тай байна.

4.2."Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын 4 чиглэлд хамаарах нийт 27 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 2026 оны хагас жилийн байдлаар 53.66%-тай байна.

4.3. Засгийн газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы 5 зорилт, 12 дэд зорилт бүхий нийт 67 арга хэмжээний хэрэгжилт 50.7%-тай байна.

4.4. Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо-чинээлэг малчин" 166 дугаар тогтоолын 2 чиглэлийн нийт 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 86.92%-тай байна.

4.5."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд олгогдсон 2522 зээлдэгдэгчид 1261.43 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг олгохдоо 372 хяналтын гэрээг байгуулсанд зөвлөмж өгснөөр дараагийн Цагаан-алт, Атрын 4 дүгээр аяны хүрээнд олгогдсон бүх зээлд хяналтын гэрээ хийсэн байна.

4.6. Дээрх төлөвлөгөө, аян, хөтөлбөрийн хүрээнд олгогдсон эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг 3-5 жилийн хугацаатай олгогдсоноос зээлийн үр дүнг тооцох хугацаа болоогүй, тогтоолын зарим арга хэмжээний суурь болон хүрэх түвшинг алдаатай, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй,

санхүүжилт батлагдаагүй, санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй, зээл хүсэгч банкны шаардлага хангаагүй, зэрим арга хэмжээнд зээл хүсэлт гаргаагүй зэрэг нь хэрэгжилтийн хувьд нөлөөлсөн.

4.7. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан төлөвлөгөө, аян, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг Засгийн шазрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-д заасан томъёо(тоон аргачлал)-гоор тооцох боломжгүй байх тул тус журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Яамны газар хэлтсийн дарга, харьяа байгууллагын удирдлага, албан хаагчдад:

5.1. 2026 оны хагас жилийн байдлаар 0%-40% буюу эрчимжүүлэх шаардлагатай болон хэрэгжээгүй үнэлэгдсэн УИХ-ын 36 дугаар тогтоолын 20, УИХ-ын 63 тогтоолын 11, Засгийн газрын 47 дугаар тогтоолын 34, Засгийн газрын 166 тогтоолын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллах;

5.2. Тогтоолуудын хэрэгжилтийн тайлан, мэдээний үнэн зөв, бодит байдлыг хангахын тулд тухайн асуудал хариуцсан бүтцийн нэгж салбарын хэмжээнд нэгтгэн боловсруулж тайлагнах, тайлангийн чанарт онцгой анхаарах;

5.3. ХХААХҮЯ, Арилжааны банк, Зээлдэгч нарын хооронд байгуулсан хяналтын гэрээг дүгнэж, зээлийн үр дүнг тооцох.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР